



Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
5-р хороо ЛэндМН ББСБ ХХК
Утас: +976-77070101
Вэб сайт: www.lend.mn

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН
БИРЖ ТӨХК-д

2018.04.09 № 2018/04363

Танай 2018.04.06 -ны № 1/198 -г

Мэдэгдэл хургүүлэх тухай

Монголын хөрөнгийн биржээс ирүүлсэн 2018.04.06-ны өдрийн 1/198 тоот албан бичигтэй танилцлаа.

ЛэндМН ББСБ ХК-ийн ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийнхээ хөрөнгийн үнэ цэнийг хамгаалах үүргийнхээ хүрээнд тодорхой нөхцөл үүссэн тохиолдолд жижиг хувьцаа эзэмшигчдийн болон нийт хувьцааны үнэ цэнийг хамгаалах зорилгоор гаргасан хувьцааныхаа 2 хувиас хэтрүүлэхгүй хэмжээнд хувьцааны үнийн хэт бууралтын эсрэг эрэлтийг үүсгэн хувьцаагаа халааслах санал, болон хувьцаа халааслах журмын төслийг хувьцаа эзэмшигчдээр хэлэлцүүлэх шийдвэрийг гаргаж энэхүү шийдвэртэй холбоотой тайлбарыг МХБ-д өгч ХНХ-д оруулах эсэх талаар чиглэл хүссэн билээ.

Монголын хөрөнгийн биржийн бидэнд ирүүлсэн компанийн тухай хуулийн 33.7 –д заасны дагуу, компани өөрийн гаргасан хувьцааг эргүүлэн авсан тохиолдолд тус хувьцаа нь компанийн зарласан боловч гаргаагүй хувьцаанд тооцогдох ба ийнхүү гаргасан хувьцааны тоог бууруулах нь үнэт цаасны бүртгэлийн III ангилалын шалгуурыг хангахгүй нөхцөлд хүргэхээр нөхцөл үүсэх тул тухайн асуудлыг ХНХ-ийн хэлэлцэх асуудлаас хасах гэсэн үүрэг даалгавар өгсөн ба үүний дагуу “Компани өөрийн хувьцаагаа эргүүлэн худалдан авах эрхийг зөвшөөрөх эсэх” асуудлыг 2018.05.10-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтаас хасч, холбогдох тайлбарыг өөрийн цахим хуудсаар олон нийтэд мэдэгдэх арга хэмжээ авч байгааг мэдэгдэж байна.

Хүндэтгэсэн,

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



М.ТҮВШИНЖАРГАЛ